



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 499

Улаанбаатар хот

Хорооны 2009 оны 271, 273 дугаар тогтоолоор
батлагдсан журам, шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дор дурьдсан агуулгатай 3.2.17¹, 3.2.17² дахь заалтыг тус тус нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3.2.17¹, 3.2.17² дахь заалт:

“3.2.17¹. МХБ-ийн “А” самбарын компанийн хувьцаа 30 хувь;
3.2.17². Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө 5 хувь;”.

2. Мөн журмын хавсралтын 3 дугаар заалтын “Зөвшөөрөгдсөн хөрөнгөөр барьцаалсан зээл” гэсэн мөрийн доор дараах агуулгатай хоёр мөрийг нэмсүгэй:

| Зүйл | Дүн | Бууруулах хувь | Тохиргоо хийгдсэн дүн |
|---|-----|----------------|-----------------------|
| МХБ-ийн “А” самбарын компанийн хувьцаа | | 30% | |
| Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө | | 5% | |

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 273 дугаар тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгагчийн хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийх, түүнд тавигдах шаардлага”-ын 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурьдсан агуулгатай 3.1.12, 3.1.13 дахь заалтыг тус тус нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3.1.12, 3.1.13 дахь заалт:

“3.1.12. МХБ-ийн “А” самбарын компанийн хувьцаа /энэ нь нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 10%-иас дээшгүй байна/ 10 хүртэл хувь, нэгжид ногдох 5 хүртэл хувь;

000860

3.1.13. Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө 5 хүртэл хувь, нэгжид ногдох 1 хүртэл хувь;”.

4. Мөн журмын 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3.1.11 дэх заалтын “... 20 ...” гэснийг “... 25 ...” гэж өөрчилсүгэй.

5. Энэ тогтоолыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

6. Тогтоолоор баталсан нэмэлт, өөрчлөлтийг журам, шаардлагад тусгаж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Хүндэтгэсэн
Хүндэтгэгч
Хүндэтгэгч
Хүндэтгэгч